



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/121

Чингис хот

Цэргийн бэлтгэл албаны сургалт зохион  
байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Цэргийн албан тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2020 оны н/03 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалахын сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний дагуу Цэргийн бэлтгэл албаны бэлтгэл офицерын сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуультай хамтран 9 дүгээр сарын 07-ны өдрөөс, 1 дүгээр зэргийн үүрэгтний сургалтыг Зэвсэгт хүчний 327 ангитай хамтран Хэрлэн суманд 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн тус тус зохион байгуулсугай.

2. Сургалтад зарцуулах төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Сургалтад хамрагдах цэргийн бэлтгэл үүрэгтэн нэг бүрт мэдэгдэх хуудас өгч бүрэн оролцуулахыг Хэрлэн сумын Засаг даргад, сургалтыг Зэвсэгт хүчний Жанжин штабын Хуурай замын цэргийн командлалаас гаргасан хөтөлбөрийн дагуу сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж дүн, тайланг илтгэхийг Цэргийн штаб /хурандаа Н.Хүрэлээ/-т тус тус үүрэг болгосугай.

4. Сургалтыг зохион байгуулахад шаардагдах 1051960 /нэг сая тавин нэгэн мянга есөн зуун жар/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Цугларалт, бэлтгэл сургууль, дайчилгаа, түр цэргийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

001910318

03 Аймгийн Засаг даргын 2020 оны  
дугаар сарын 06 өдрийн 14/31  
дугаар захирамжийн хавсралт

Цэргийн бэлтгэл албаны сургалтын төсвийн задаргаа

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1	АИ 92	Литр	238	1910	454580	
2	Дизель түлш	Литр	238	2510	597380	
	<b>Нийт дүн</b>				<b>1051960</b>	